

БАТЛАВ.
ЦАГ УУР, ОРЧНЫ ХИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

..... Э.БАТТУЛГА

20¹⁵ оны 04 дугаар сарын 18 -ны өдөр

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАН,
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго: Монгол улсын Засгийн газраас Байгаль орчны салбарын эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 1997 онд батлагдсан Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний тухай хууль (УЦУОХШТХ)-ийг шинэчлэн найруулсан хуулийн төслийг боловсруулах юм.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангасан орон нутаг, салбарын байгууллагуудаар хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгасан байна.

Гүйцэтгэх ажлууд:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг боловсруулах
- УЦУОХШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, шинэчилсэн найруулга хийх хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах ажлын тайлан, УЦУОХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалтай нийцүүлэх,
- УЦУОХШТХ-ийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийн хэлэлцүүлгийг салбарын хэмжээнд зохион байгуулж, саналыг тусгах

Хугацаа: Гэрээ байгуулснаас хойш ажлын 30-40 хоногт

Ажил гүйцэтгэх байгууллагаад тавих шаардлага:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь 7-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай хуулийн этгээд байх бөгөөд 3-аас доошгүй орон тооны мэргэжлийн ажилтантай байна.
- Тухайн ажлын гүйцэтгэгчээр сонгогдсон тохиолдолд энэхүү ажлыг хариуцсан ажилтан ажиллуулах
- Хууль эрх зүйн чиглэлээр ажилладаг, хууль тогтоомжийн талаар судалгаа шинжилгээ, хуулийн төсөл боловсруулж байсан туршлагатай байх
- Байгаль орчны салбарын эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх
- Гүйцэтгэсэн ажлаар тухайн хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл батлагдах хүртэл зөвлөмж, тодруулга, асуулт, тайлбар гарган өгөх,

- Харилцааны өндөр мэдлэгтэй, захиалагч байгууллагуудын багтай хамтран ажиллаж ойлголцох ур чадвартай, багаар ажиллах, гүйцэтгэсэн ажлыг бүрэн хариуцах чадвартай байх,
- Мэргэжилтнүүдийн товч танилцуулга, мэргэжлийн болон мэргэшлийн талаар нотлох баримтууд

Захиалагч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) болон Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)

Санхүүжилтийн эх үүсвэр: НҮБХХ-ийн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох” төсөл

Тайлагналт: Хууль тогтоомжийн тухай хууль, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг 2 хувь үйлдэж цаасан болон файлаар хүлээлгэн өгнө.

Санхүүжилт: Энэхүү ажлын нийт төсөв 19,890,000 (арван есөн сая найман зуун ерэн мянга) төгрөг болно. Үүнд ажил гүйцэтгэгчийн ажлын хэлс, ногдож болох аливаа татвар, хураамж, шимтгэл бүгд багтана. Тайлан, судалгааг бүрэн хүлээлгэн өгснөөр гэрээг дүгнэн санхүүжилтийг олгоно.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР